

ARTICLE

Монгол аман зохиол дахь өвгөний дүрийн домог зүйн үүтгэл ба шилжилт

Ли ХЁНБУК*

Монгол Улс, Улаанбаатар,
Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны
сургууль, Хүмүүнлэгийн ухааны салбар,
Утга зохиол, урлаг судлалын тэнхим

Email: 24M1NUM1138@stud.num.edu.mn, nomad.hyeonbok@gmail.com,
<https://orcid.org/0009-0004-2420-8620>

Ганбаатарын НАНДИНБИЛИГ**

Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх ухааны сургууль, Хүмүүнлэгийн ухааны салбар,
Утга зохиол, урлаг судлалын тэнхим

Email: нандин@num.edu.mn,

Received: October 10, 2025 | **Accepted:** December 13, 2025 | **Published:** December 30, 2025

Хураангуй: Тус өгүүлэлд монгол аман зохиол дахь өвгөний дүрийг домог зүй, зан үйлийн онолын үүднээс судлахыг зорьжээ. Судалгаандаа Ж.Фрэзер, С.Дулам нарын домог зүйн судалгааны үзэл баримтлал болон В.Хайссиг, Ли Анна нарын шашин шүтлэгийн судалгааны тайлбарыг хэрэглэн, монгол аман зохиол дахь өвгөний дүрийг шинжлэн задалсан байна. Судалгааны дүнгээс харахад домог зүйн шатанд өвгөний дүр нь бурхан, үлэмж туурвигч, уулын эзэн хийгээд өвгөн баатрын дүрээр илэрч байсан бол баатарлаг туульсын шатанд хүү баатрын эцэг юм уу адуучны дүрээр илэрч байна. Монгол аман зохиол дахь энэхүү олон чиг үүрэг бүхий өвгөний дүрийн цаана “бутны эзэн-бурхан” хийгээд “өөг дээдсийн онгод” гэх эртний шүтлэгийн ойлголт хадгалагдаж байгаагийн зэрэгцээ мөн “бурхан” шинжээ алдаж, улмаар баатарлаг туульсын шатанд өвгөний дүр нь хүү баатарт гол дүрийн байр сууриа алдан, баатрын эцэг эсвэл

* © Ли Хёнбук, 2025; Холбоо барих зохиогч

** © Г.Нандинбилиг, 2025

туслагч адуучны дүрээр үлдэж хоцорсныг домог, туульсын олон жишээн дээр шинэжлэн судлав.

Түлхүүр үг: Домог зүй, өвгөн, бурхан, өвөг дээдсийн онгод, уулын эзэн

The Mythological Origins and Transitions of the Old Man Figure in Mongolian Oral Literature

HYEONBOK Lee

*Department of Literature and Art Studies, Division
of Humanities, School of Arts and Sciences,
National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia*

NANDINBILIG Ganbaatar

*Department Literature and Art Studies, Division
of Humanities, School of Arts and Sciences,
National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia*

Abstract: *This article explores the figure of the ‘övgön (old man)’ in Mongolian oral literature from the perspectives of mythology and ritual studies.*

Drawing on the theoretical frameworks and methodologies of James George Frazer and Sendenjav Dulam in mythological research, as well as the conceptual approaches to religious beliefs developed by Walter Heissig and Lee Anna, the study analyzes the roles and functions of the övgön in Mongolian oral narratives.

The findings show that the övgön appears in diverse forms: as a deity, a mountain spirit, a wise diviner or astrologer, the hero’s father, a helper, a herdsman, and occasionally even as the hero. Beneath these multifaceted roles lies the concept of the bush spirit-ancestral tutelary deity. Over the course of the evolution of oral narratives in terms of content and character roles, the divine attributes of the övgön tend to diminish, while the övgön assumes primarily the roles of the hero’s father or helper. The study also observes transformations and transitions in the övgön’s figure, exhibiting a combination of divine and human traits, as well as certain functions of both hero and helper.

Keywords: *Mythology, övgön (old man), ancestral tutelary spirit, deity, mountain spirit*

Удиртгал

Монгол хэлний ӨВГӨН (ᠥᠪᠭᠦᠨ, эбүгэн) гэдэг нь зөвхөн өтөл насны хүн гэх утгаас гадна угсаатны зүй, домог зүй, аман ба бичгийн зохиолын талаас нарийвчлан судалбал сонирхолтой дүр мөн билээ. Өвгөн хэмээх үгийн олон тооны хэлбэр болох өвгөд нь өвөг дээдэс гэх утгатай бөгөөд энэ үгийн нийлмэл үгэнд ‘өвгөдийн үг’, ‘өвгөдийн онгон’, ‘өвгөд дээдэс’ гэх зэрэг үг ордог. Энэ үгнүүд бүгд нь ‘өвөг дээдсийн’ шүтлэгтэй холбогдож байгаа юм.

Сэдвийн судлагдсан байдал: Монгол домог шүтлэгт уламжилсан өвгөний дүрүүдээс одон эрхсийн домгийн “Долоон өвгөн” болон Цагаан өвгөний дүр судлаачдын анхаарлыг татсан байдаг.

Германы алдарт монгол судлаач В.Хайссиг “Монголын шашин суртахуун” (1970) бүтээлдээ долоон өвгөн одны шүтлэгийн тухайд “Монголчууд заяа тавиланг удирддаг бурхнаар долоон одыг тахин шүтдэг бөгөөд өнөөх одыг долоон өвгөн гэж дууддаг” (2003: 160). “Энэтхэгийн маанийг үндэслэн авсан долоон өвгөний тухай залбирал, магтаалууд монгол, уйгур хэлээр орчуулагдаж, 1330 онд Бээжинд хэвлэгдсэн (2003: 161) бөгөөд ард түмний дунд ч ан гөрөө, мал аж ахуйн аз хийморь, тэгш шударга сайн хаан эзэн, дайны удирдагчтай болохыг долоон өвгөнд залбирч хүсдэг” (тэнд, 163) гэсэн бол Цагаан өвгөний тухайд “Монголын янз бүрийн маанид Цагаан өвгөн бол дандаа ‘Луун толгойт таягийг тулж, цагаан дээл өмссөн цагаан буурал сахалтай өвгөний дүрээр илрэн гардаг” (2003: 150) гээд, Цагаан өвгөн нь уул усыг хамаардаг бөгөөд газар болон усанд оршдог бүх онгодын удирдагч, хүн, малын амь хийгээд үхлийг удирддаг. Баруун монголын тахилга, тайлгын зан үйлийг үзэхэд дэлхийн өвчин ба чөтгөр шуламсыг устгаж өгдөг сахиус ч болдог юм. Түүнчлэн бөөгийн хэрэглэдэг илбийн таяг мэт хэрвээ таягаараа малд хүргэвэл малыг өвчлүүлж ч чадах хүчтэй байдаг гэж итгэдэг байсан гэжээ.

Монгол домог зүйг судалсан эрдэмтэн С.Дулам “Монгол домог зүйн дүр” (1989) нэг сэдэвт бүтээлдээ “Бурхан Халдун уул”-ын нэрийн гарал хийгээд “Долоон өвгөн” одны домгийг судлах явцдаа “бурхан”, “өвгөн” гэдэг хоёр үг хоорондоо чухал учир холбогдолтой байгааг ажиглаж, улмаар “бурхан” гэдэг үг “өвгөн” гэсэн утгатай болохыг домог, түүхийн сурвалжаар нотолсон байна. Тэрээр энэхүү судалгааны хүрээнд “Бурхан Халдун уул гэдэг нь “өвгөдийн бургастай уул” гэсэн утгатай бөгөөд эрт цагтаа “бургасны эзэн” гэх утгаар Халдун бурхан гэж нэрлэж байсан байж болзошгүй” (1989: 56), “Монгол домог зүйд сүүлдээ “бурха, бурхан” гэдэг нь мод бутны эзнийг нэрлэхээ болиод, зөвхөн нөгчиж дээдсийн газар очсон өвгөдийг юм уу, ариун дархан халдун бургасаар урлаж хийсэн дүрс тэмдгийг хэлдэг болсон бололтой” (1989: 56), “Монгол домог зүйд ертөнцийг үүсгэн бүтээгч туурвигч баатар Бурхан гэж гардаг нь эрт нэгэн цагт ертөнц, хүнийг болон соёлыг үүсгэсэн “өвгөн дээдэс” гэсэн үг юм” (1989: 58) гэх мэт олон чухал санааг дэвшүүлээд, “Бурхан гэдэг үг өвгөн гэсэн утгатай байдаг нь ардын аман уламжлалд ч өнөө хэр буй бөгөөд мөнөөх хожмын буддын шашны нөлөөнөөс болоод хүн анзаардаггүй буюу анзаарах ч аргагүй болсон байна” (1989: 57-58) гэж үзсэн нь монгол үлгэр туульс дахь өвгөний дүрийн домог зүйн үүтгэлийг судлахад суурь ач холбогдолтой байна.

Солонгосын монгол судлаач Ли Анна “Монгол ардын шашин шүтлэгийн судалгаа” (2010) номдоо “Ерөнхийдөө уул усны шүтлэг нь газрын шүтлэгийн нэг бөгөөд газар эх бурхан-Этүгэн эхэд хамаарах шүтлэгийн хэлбэр юм. Эрт дээр үед уулыг өвгөд дээдэс бурхны оршдог газар гэж үздэг байсан ба тэрний эзэн нь алдар нэртэй бөөгийн сүнс сүлд юм уу онгод (өвгөд дээдийн сүнс сүлд)-оос үүссэн” гэж тэмдэглээд онгод гэдэг ойлголт нь Буддын шашин дэлгэрснээс хойш лус савдаг болон хувирч, уул усны шүтлэг бас эцгийн эрхт нийгэмд шилжсэнээр тэнгэрийн шүтлэгтэй ойр дотно холбогдохоор болсон” (2010: 387) хэмээн өгүүлэв. Долоон өвгөн одны талаар Ли Анна бас “Оддын шүтлэгийн дунд хамгийн чухал, түгээмэл нь долоон одны шүтлэг мөн. Долоон одыг долоон бурхан юм уу долоон өвгөн гэж ч хэлдэг бөгөөд ‘бурхан’ ба өтөл насны эрэгтэй

хүнийг илэрхийлдэг өвгөн гэдэг нь бүгдээрээ өвгөд дээдсийн бурхны онцлог багтдаг” (2010: 83). Түүнчлэн “Долоон од зөвхөн хүний амь, үхэл биш аз ба золгүй явдал, сайн муу зүйл, цэцэглэн хөгжих, элбэг дэлбэг, хүн төрөлхтний ерөнхий хэргийг бүгдийг удирддаг од бөгөөд өргөн хүрээнд авч үзэхэд өвөг дээдсийн бурхны ухагдахуун (идеа) багтдаг” (тэнд, 88) хэмээн С.Дуламын саналыг дэмжсэн байна.

Монголын эртний домог, баатарлаг тууль, түүх домог, үлгэр аман зохиолын төрлүүд, бөө мөргөлийн болон буддын шашны ёсонд олон янзын өвгөний дүр гардаг боловч судлаачид монгол аман зохиол дахь өвгөний дүрийг тусгайлан судалсан судалгаа тун ховор байна.

Судалгааны зорилго, зорилт: Монгол домог зүйн өвгөн (бурхан)-ий дүрээс хэрхэн уулын эзний дүрд шилжиж, улмаар эртний домгийн гол дүр өвгөн хэрхэн үлгэр туульсын туслах дүр болж хувирсныг домог, туульсын тодорхой жишээн дээр авч үзэн, ангилах болно. Үүний тулд нэгдүгээрт монгол домог, туульс, үлгэрт гардаг өвгөний дүрийг бүртгэн ангилна. Хоёрдугаарт өвгөний дүрийн домог зүйн үүтгэл болон шилжилтийг тодруулна. Гуравдугаарт домог зүйн дүрийн тогтолцоонд гол дүр байсан өвгөний дүр нь хэрхэн туульс хийгээд ардын үлгэрт туслах дүр болж хувирсныг тайлбарлана.

Судалгааны арга, эх хэрэглэгдэхүүн: Монгол домог, туульс дахь өвгөний дүр бол домог зүйн дүр болон зан үйлтэй нягт холбоо хамааралтай учир энэхүү судалгаанд Ж.Фрезер болон С.Дуламын домог зүйн судалгааны үзэл баримтлалд тулгуурласан бөгөөд С.Дуламын “Монгол домог зүйн дүр”, В.Хайссигийн “Монголын шашин суртахуун”, Ли Аннагийн “Монгол ардын шашин шүтлэгийн судалгаа” зэрэг судалгааны бүтээлүүд нь энэхүү судалгаанд ач холбогдолтой юм. Эх хэрэглэгдэхүүний хувьд энэхүү судалгаанд Д.Цэрэнсодномын эмхэтгэж, удиртгал тайлбар бичсэн “Монгол ардын домог үлгэр”, Х.Сампилдэндэвийн эмхэтгэсэн “Монгол домог”, “Монгол домгийн чуулган”, Б.Катуугийн эмхэтгэсэн “Баян-Алтайн гуч Э.Баатаржавын хайлсан туульс”, Р.Нарантуяагийн эмхэтгэсэн “Халх ардын тууль” зэрэг эмхэтгэл номуудаас жишээ баримтаа авч ашиглав.

Үндсэн хэсэг

1. Домог зүй дэх өвгөний дүр

Уг судалгаанд эртний домог (myth) хийгээд хүүрнэн өгүүлэх аман зохиолын нэг гол төрөл зүйл болох түүх домог (legend)-ийн зарим жишээнээс өвгөний дүрийг бүртгэн ангилах замаар домог зүйн дүрийн тогтолцоонд гол дүрийн үүрэгтэй байсан өвгөний дүр нь үлгэр, туульсын дүрийн тогтолцоонд хэрхэн туслах дүр болж хувирсан шилжилтийг тодруулах болно.

Д.Цэрэнсодномын эмхэтгэсэн “Монгол ардын домог үлгэр” номын үлгэрүүдэд өвгөний дүр гардаг эртний домгууд болон зарим түүх домгийн өвгөний дүрийг шинжлэн судлав. Учир нь монгол тууль болон хүүрнэн өгүүлэх аман зохиолд гардаг өвгөний дүрүүдийн анх үүтгэл хэлбэр нь эртний домогт илэрч гардаг гэж үзсэн ба үүнд бурхан, газар болон уулын эзэн, үлэмж биет баатар, мэргэн төлөгч дүр хамаарна.

1.1. Бурхан-өвгөн

Монгол аман зохиол дахь өвгөний дүрийг эртнээс хөөн, домог зүйн дүрийн *ur-form*¹ үүтгэлийг мөшгөж хайя гэвэл хамгийн эртний домог зүйн өгүүлэмж болох наран, саран, одон эрхсийн үүслийн тухай домгоос эхэлж үзэх нь зүйтэй (Нандинбилиг, Дулам нар: 2020: 42). Одон эрхсийн домгийн өвгөний дүрүүдээс хамгийн зонхилох өвгөний дүр бол “Долоон бурхан од”-ны домгийн долоон өвгөн мөн.

“Монгол ардын домог үлгэр” номд долоон одны үүслийн тухай домгийн нийт найман хувилбар нийтлэгдсэнээс “Долоон бурхан (А)”, “Алхай мэргэн (Б)”, “Долоон өвгөн (В)”, “Алтан гадас, долоон бурхан хоёр (Г)”, “Алтан гадас, долоон бурхан хоёр (Д)”, “Ам цагаан бяруу (Е)”, “Үүрийн цолмон ба долоон бурхан”, “Тэнгэрийн зам ба долоон бурхан” домгийг энд авч үзэж байна. Мөн “Гурван марал од”-ны үүслийн тухай домгийн дөрөвдүгээр хувилбар буюу “Хөхдэй мэргэн (Г)” одны домогт долоон өвгөний дүр илэрч гарав. Уг есөн хувилбарын дунд өвгөний дүр гарч буй нь “Долоон өвгөн”, “Алтан гадас, долоон бурхан хоёр (Г)”, “Ам цагаан бяруу”, “Хөхдэй мэргэн (Г)” дөрөв болно.

“Алтан гадас, долоон бурхан хоёр” болон “Ам цагаан бяруу” домогт өвгөн тус тусад нь долоон одны үүсэл болсон хөвгүүд, бярууны эцгийн дүрээр илэрч байна. “Алтан гадас, долоон бурхан хоёр” домогт Хангарди шувуу шүүрээд явсан гүнжийг олж ирэхийн тулд хаан зурхайч нараас асуутал “...Зурхайч нар таны гүнжийг олж ирж чадах хүн албат нарын чинь дотор найман хүүхэдтэй нэгэн өвгөн байна. Тэр тус болох юм байна гэж мэргэцгээжээ” (Цэрэнсодном, 1989: 66) гэж өвгөн өөр өөр хүч чадвартай хүү баатруудын эцэг болон зурхайчийн дүрээр илэрч байгаа бол “Ам цагаан бяруу” домогт өвгөн “Бүх эрж цөхөөд өөрөө бүх орлосон юм байх. Тэгээд үнээ нь тугалласан чинь цээжин бие нь хүн шиг, бөгс нь урт сүүлтэй үхэр шиг амьтан гарч гэнэ” (тэнд, 67) хэмээн амьтан-хүний заримдаг төрхт баатрын эцгийн дүрээр илэрч байна.

Харин “Долоон өвгөн” домогт өвгөн “...амнаас нь хүүгийн хэлийг татаж гаргаад далан зүүгээр хатгаад авч гэнэ. Хүү тэгсхийгээд сэрсэн чинь өвгөн алга болсон байв. ... Үнэндээ тэр хүүгийн хэлэнд өвгөн зүү хүргэснээс болж тэр бүх амьтны хэл мэддэг болсон байжээ.” (тэнд, 63-64) хэмээн шидэт баатрын туслагч буюу хүч чадвар соёрхогч дүрээр гарч байна. Гол дүр болох ядуу хүү өвгөнтэй ойд тааралдаж бүх амьтны хэл мэддэг чадварыг олсноос үзэхэд өвгөн газар усны эзний шинжтэй бөгөөд хүч чадлаа олсон ядуу хүү яваад, өөр өөр хүч чадвартай зургаан хүнтэй тааралдаж, ах дүүс болоод газар доорх оронд очиж, эрийн гурван наадмаар өрсөлдөж, хааны долоон гүнжийг авах болдог. Уг домогт гарч буй долоон хүү нь шидэт баатрын дүр болох ба энэ бүгдэд хүч чадал соёрхсон өвгөний дүр байсан гэж таамаглаж байна.

“Хөхдэй мэргэн (Г)” домогт “Тэр үед мангас хамаг амьтныг хөнөөж залгаад зөвхөн долоон өвгөн үлдсэн нь өндөр уулын оройд гараад уйлалдаж, тэнгэрт мөргөж залбирч суужээ. Эцэг Малиан тэнгэрийн илгээсэн Хөхдэй мэргэний ачаар энэ долоон өвгөнөөс одоогийн хүн үүсэж үржсэн юм гэнэ” (тэнд, 50) хэмээн өвгөнийг хүн төрөлхтний өвөг дээдсийн дүрээр дүрсэлсэн бөгөөд уг домгийн текстэд уг долоон өвгөн бурхан болж тэнгэрт гараад, долоон од болсон тухай өгүүлээгүй ч цаана нь долоон одыг долоон өвгөн буюу долоон бурхан гэж

¹ Primordial form / original form / archetypal form. Өөрөөр хэлбэл Urform гэдэг нь тухайн домог, аман зохиол, дүрслэл эсвэл хэлбэрийн хөгжлийн суурь болсон, хамгийн эртний үеийн язгуур хэлбэр буюу үүтгэл загвар юм.

үздэг сэтгэлгээ юм.

Харин өвгөнийг бурханчлан дүрсэлж шүтдэг болсон учрыг “Хөхдэй мэргэн” домгийн өөр нэгэн хувилбарт тайлбарлаж байна. Б.Ринчен анх нийтийн хүртээл болгож, хожим Х.Сампилдэндэвийн “Монгол домог” номд нийтлэгдсэн тус домгийн хувилбарт *“Ойролцоох онцгой тод одыг Хөхдэй мэргэн аян дайнд унадаг хоёр шарга морио аргамжсан гадас юм гэнэ лээ гэлцдэг. Тэр хоёр шаргыг долоон өвгөн сахин манаж, шөнө хоёр шаргыг дагаж, алтан гадсыг эргэж явдаг гэж хэлэлцдэг. Тэр долоон өвгөнийг бас долоон бурхан ч гэж нэрлэдэг. Аль дээр цагт тэнгэрт дэвшиж, дээд тивд гарсан өвгөдийн хойчийг хүн бурхан гэлгүй яах вэ? Хальсан хүнийг бурхан боллоо гэж хэлдэг ёс бий”* (Сампилдэндэв, 1999: 5) гэж тайлбарладаг. Хүн төрөлхтөн эртний үед бурхны дүрийг байгаль орчим, амьтан юм уу домгийн амьтнаас олж авч дүрсэлж байгаад түүхийн явцад хүн төвт үзэл (Грекууд үүнийг *Hellenism* гэж нэрлэдэг байсан) үүсэж, үүний нөлөөнд бурхны дүрийг хүншүүлэн дүрсэлдэг болсон. Монголчуудын бурхны дүрийг анх хүншүүлэн дүрсэлсэн нь хүн нас барж од болон бурхан болдог гэсэн үзэл төсөөлөл бий болсонтой холбогдож үүссэн өвгөний дүр гэж үзэж болно. Мөн монгол домог зүйд гурван ертөнцийг тэнгэр нэр оршин суудаг дээд тив (тэнгэрийн орон), хүн амьтны өлгий дунд тив, Эрлэг, чөтгөр, шуламсыг эзлэн байдаг доод тив (тамын орон) гэж үздэг (Дулам, 2020: 50) ба бурхан гэдэг нь тэнгэрийн орон буюу “дээд тив”-д гарсан өвгөн гэж үзсэн нь монгол аман зохиолд тэнгэрийн шинжтэй оршихуйн үзэгдэх дүрийг өвгөн настайгаар төсөөлдөг байсныг таамаглах боломжид хөтөлсөн юм.

Монгол Улсад аж төрж буй түрэг хэлт угсаатны нэг болох тувачуудын эртний домгийн дунд мөн адил долоон одны үүслийн тухай домог уламжилжээ. Жишээлбэл “Долоон бурхан одны тухай домог”-т *“Тэнгэрт орой болгон гардаг сар, од мөн нарыг эрт дээр үед газарт амьдарч байсан бидний өвөг дээдэс байсан ба улмаар хөгширч тэнгэрийн од болон халин оддог хэмээн үздэг байсан”* (Д.Өрнөхдэлгэр, Г.Нямдаваа нар, 2022: 94) гэж од мичдийг өвгөн гэж хүншүүлдэг тухай тайлбарласан байна. Мөн уг домогт ч долоон шар үстэй хүүтэй өвгөн эмгэн хоёр гардгаараа монголчуудын “Алтан гадас, долоон бурхан хоёр”, “Ам цагаан бяруу” домогт гарч буй баатруудын эцэг өвгөний дүртэй адилхан байна.

Солонгос ардын аман зохиолд ч мөн долоон одны үүслийн тухай домог болон үлгэр улс даяар түгээмэл тархсан байдаг ба өөр өөр нутгаас нийт есөн хувилбар тэмдэглэн авч хэвлүүлээд олон нийтэд танилцуулсан байдаг (정인섭, 2007: 62). 1930 онд солонгос аман зохиол судлаач Сон Жин Тэ-ийн тэмдэглэсэн шидэт үлгэр “Долоон од ба богинохон наслахаар заяагдсан хөвгүүн” үлгэрт шидэт лам (신승; 神僧: шууд утгаар бурхан лам гэсэн үг)² болон хоёр арш гардаг. Уг үлгэрт шидэт лам ганц хүүтэй хүнд *“Танай хүүхэд 19 хүрэхгүй нас барах болно”* гэж зааж өгтөл аав нь хүүгээ урт наслуулах аргыг асууж гуйв. Гурван удаа гуйхад нь шидэт лам арга буюу *“Маргааш Намсан уулын оргилд гарахаар нь хоёр арш даам тоглож байх байх. Тэр хоёрт өвдгөө сөгдөн гуйвал ямар нэг аргыг хайлж өгнө”* гэв. Шидэт ламын хэлсэн дагуу хүү нь ууланд гарч энэрэнгүй арш, муу арш хоёроос гуйтал энэрэнгүй арш нь хүүг өрөвдөж тусалъя гэхэд муу

² Чухамдаа солонгос ардын аман зохиол дахь шидэт лам бол өвгөний буддын шашин нөлөөлж хувирсан дүр болно.

арш хүлээн зөвшөөрөөгүй. Хоёр арш ярилцсаны эцэст нь муу арш арга буюу хүлээн зөвшөөрч, өврөөсөө амь насны судраа гаргаж, хөвгүүний насыг 19-өөс 99 рүү засаж өгөв. Муу арш нь долоон од байсан ба хүний амь нас бол долоон од бурхны эрхэлдэг хэрэг юм (Сон Жин Тэ, 2009: 144-145) гэдэг. Солонгос ардын шашин шүтлэг болон бөө мөргөлийн зан үйлд хамгийн чухалд авч шүтдэг бурхны нэг нь долоон од бурхан (칠성신; 七星神) байдаг нь уг домогт туссан ба монгол домогт тодорхой гардаггүй долоон өвгөний одон эрхсийн шүтлэг болон зан үйлийн дүр солонгосын энэхүү домогт ил тод гарч байгаа юм.

1.2. Үлэмж биет туурвигч өвгөн

Ертөнцийн үүслийн домогт Бурхан хэмээх тэргүүн туурвигч баатар гарах бөгөөд үлэмж биет өвгөний дүрээр төсөөлөгдөнө. Түүнчлэн монгол ардын уул усны домгийн алс эртний өгүүлэмж бүхий зарим хувилбарт үлэмж биет туурвигч баатар гарах бөгөөд бурхан буюу өвгөний дүрээр илрэх нь цөөн бий. Жишээлбэл, ертөнцийн үүслийн домгийн хүрээнд хамаарах “Өвөл зун яагаад ээлжилдэг вэ?” хэмээх улирлын үүслийн учрыг тайлбарласан домогт туурвигч баатар нь өвгөний дүрээр илэрч байна. Тухайн домогт тус тус есөн хоногт дэлхий ертөнцийг хөлдөөх хүйтнийг удирддаг өвгөн болон үүнийг найман өдөрт л хайлуулж усан далай болгох халууныг удирддаг өвгөн гэсэн улирлын туурвигч баатрууд нь үлэмж биет өвгөний дүрээр дүрслэгдэж байна (тэнд, 43). Эдгээр өвгөн туурвигчид нь чиг үүргийн хувьдаа хүн ба амьтны үхэл, амьдралыг шийдэгч Цагаан өвгөний дүртэй төсөөтэй байгаа юм.

Монгол нутагт гүрэн байгуулсан эртний түрэгчүүдийн домогт дээрх хүйтний өвгөн дулааны өвгөнийг санагдуулам дүр гардаг. Хятадын түүхэн судрын нэг болох Бэй ши (北史) шастирт Түрэгүүдийн Асен овгийн угсаа гарвальный түүх домгийн гурван хувилбар нийтлэгдсэн байдаг. Нэг хувилбарт Хүннүгийн хойд талаас гаралтай Түрэгүүдийн өвөг дээдэс нь арван долоон ах дүүс байсан гэв. Отгон хүү болох Ижинисиду (伊質泥師都) чонын хувилгаан байсан ба багаасаа онцгой хийморь сүлдийг мэдэрч, салхи бороог чадавхтайгаар зөгнөн тодорхойлж чаддаг байв. Тэр хоёр эхнэр авсны нэг нь өвлийн бурхны охин, нөгөө нь зуны бурхны охин байв. Хоёр эхнэрээс дөрвөн хүү төрсөн ба ууган хүү нь эртний Түрэг улсыг байгуулж, түүний бага эхнэрээс төрсөн хүү нь Асен байсан гэдэг³. Уг домогт хүйтэн өвлийн улирлыг яаж даван туулах нь чухал асуудал болдог. Уг домогт гарч буй өвлийн бурхан, зуны бурхан хоёр “Өвөл зун яагаад ээлжилдэг вэ?” домогт гарч буй хүйтний өвгөн, дулааны өвгөн хоёртой адил юм. Мал аж ахуй эрхэлдэг хээр талын нүүдэлчдийн өвлийн улирлыг өнтэй давж, малын сүргээ хүйтнээс хамгаалж амьд үлдэх хамгийн чухал бөгөөд хүйтний өвгөн, дулааны өвгөний дүр нь тийм нөхцөл байдлын нөлөөнд үүссэн нүүдэлчдийн хүншүүлсэн бурхны дүр болно.

Үүнээс гадна үлэмж биет баатрын дүрээр илэрдэг домгийн өвгөний нэг жишээ бол “Байгаль эцэг, Ангар охины тухай домог” болно. “*Эрт урьд цагт Сибирь нутагт Байгаль гэдэг өвгөн буурал баатар эр байжээ*” (Сампилдэндэв, 1999: 348) гэж Байгаль нуурыг хүншүүлэн, өвгөний дүрээр дүрсэлсэн байна.

³ “北史” 卷九九 ‘突厥傳’, 3285-3286, дахин эшлэв: Jae-hun, Jeoung. Dolgoel Yumoek Jeguksa. [The History of the Turkic Nomadic Empire]. Seoul: Sagejul printing. 2005, 120.

Байгаль өвгөн Ангар гэдэг цорын ганц үзэсгэлэнтэй охинтой байсан ба охиноо хатуу захиран, гадагш ер гаргадаггүй байв. Ангар охин Енисей гэдэг үзэсгэлэнт сайхан баатар эрийн тухай сонсож, бурханд залбирч олон горхинуудын тусламжтайгаар эцгээ нам гүн унтаж байхад зугтана. Эвгүй зүүд зүүдлэн, гэнэт сэрсэн өвгөн зугтаж байгаа охиныхоо араас чулуудваас “...шидсэн чулуу нь том цохио болж тогтсон бөгөөд хүмүүс түүнийг бөөгийн чулуу гэж нэрлэх болжээ” (тэнд, 349) гэдэг. Өнөөдрийг хүртэл буриад монголчууд Байгаль нуурыг Байгаль өвөө гэж дууддаг нь энэ домогтой холбоотой. Үлэмж биет баатар болох Байгаль өвгөний шидсэн чулуу өнөөгийн бөөгийн чулууны үүсэл болсон гэдэг нь үлэмж биет баатрын туурвигч шинжийг үзүүлж байгаа юм. Гэвч монгол нутгийн газар усны түүхэн домогт үлэмж биет туурвигч баатар гардаг ч өвгөний дүрээр илрэх нь түгээмэл биш юм.

1.3. Уулын эзэн өвгөн

Долоон одны домгуудад ах дүү бурхдын дүр нь өвгөний дүрээр илэрч байгаа бол наран сарны домогт өвгөний дүр нь уулын эзний дүрийн үүтгэл болж илэрдэг. Наран сарны домгийн “Нар сар хоёр” хэмээх домогт “*хамаг адгуус амьтад, хүүхэд хөгшигчүүл бүх хүн барьж иддэг мангас махчныг*” дарахын тулд хүмүүс тэнгэр нараас зөвлөгөө авч, Хайрхан ууланд байдаг ганц хүүтэй өвгөн эмгэн хоёрт хандана. Гадна талаас харахад уг домогт илэрч буй өвгөн эмгэн хоёр баатрын эцэг эхийн дүр мэт харагдавч хайрхан өндөр ууланд оршдог уулын эзний шинжтэй юм. Тус домогт “...хүү мангасын амин газрыг нь олж хатгаад алж орхив. Аюулт хар мангасыг амьсгаа хураамагц гэрэлт нар мандан гарч хорвоог гийгүүлэхэд хүн амьтан баяр хөөр болж Хайрхан уулын хүүг баатар гэж өргөмжилжээ” (Цэрэнсодном, 1989: 45) хэмээн өгүүлснийг үзэхэд уг домогт бүх хүн амьтан өвгөний хүүг Хайрхан уулын хүү гэж баатраар өргөмжлөн, өвгөн ба хайрхан уул хоёрыг адилтгаж үзсэн байна. Үүнийг монгол ардын аман зохиол дахь уулын эзэн өвгөний дүрийн үүтгэл гэж үзэж болох юм.

Мөн “Муумянганы домог” хэмээх угсаа гарвалийн түүхэн домгийн нэгэн хувилбарт уулын ой шугуй болон ан амьтдын эзэн баян хан Мани өвгөн гэж гарч байна. Домогт өгүүлснээр “... гэнэтхэн тас хар царайтай, нэг алд сахалтай өвгөн ирж, авын түрүү Чингист уулзаж: Би Чингис танд айлтгах хэдэн зүйл учир байна. Миний нэрийг баян хан Мани гэдэг юмаа. Би 123 настай. Миний эмгэн 117 настай. Би бол хан дэлхий дээр байх хамаг гөрөөсийг хамаарч, эзэлж суудаг билээ. Миний харьяалж байдаг зээр, туулай, буга, үнэг, барс, ирвэс тэргүүтэн цөм минийх” (тэнд, 172) гэж газрын эзний дүрийг өвгөн настайгаар үзүүлсэн ба ан амьтдын заримыг нь Чингис хаанд өтгөлж өргөх учраас заримынх нь амийг өршөөн хайрлаарай гэсэн ч Мани өвгөний үгэнд оролгүй анчид нь өөрсдөө мэдэн барьж иднэ гэв. Чингис хаан ан гөрөөнд явахдаа үнэгэн шулам, догшин гөрөөс, алмас, тийрэн гэх мэт домгийн амьтад бүгдийг дарж устгадаг бөгөөд цагаан үнэгэн шулмыг хөөж агуйн дотор ороод явж байтал Хүнхэ гэдэг шар өвгөнтэй тааралдан “...Яасан олон тайга нохой дагуулж, тал дүүрэн бэлчиж явдаг юм? Өвгөн би үзвэл талд байх гөрөөсийг тааваараа барьдаг янзтай...” (тэнд, х.173) гэх мэтээр Чингис хааныг загнадаг. Энэхүү шар өвгөн ч мөн ан амьтад, ой шугуйг захирагч уулын эзний дүрээр гарч байна. Шар өвгөнийг алах гэсэн Чингис хааныг түүний хамгийн шилдэг шар тайга нохой нь тэр өвгөний гурван хүү цагаан үнэгэн шулмыг барихад тус хүргэнэ хэмээн болиулдаг.

Эцэст нь шар өвгөний гурван хүүгийн тусламжтайгаар цагаан үнэгэн шулмыг дарсан Чингис хаан *“Хонхир хэрдэг шар өвгөнийг мянган шар тайлгыг муутган хэлсэн болохоор Муумянган хошуу болгон захируулж ноён суулгав”* (тэнд, 174) хэмээн Муумянган овгийн үүслийг тайлбарлаж байгаа бөгөөд энд гарч буй шар өвгөн нь уулын буюу газрын эзний дүр төдийгүй нэгэн овгийн өвөг дээдсийн дүрээр илрэн гарч байгаа юм.

1.4. Өвгөн баатар

Домог, тууль дахь өвгөний дүр нь олонхдоо баатруудын эцгийн дүрээр юм уу, эсвэл баатруудын хүч чадварын үндэс язгуур, ид шид соёрхогч болгон үзүүлдэг бол өвгөн өөрөө баатрын дүрээр гардаг нь ‘Түмэн хар хоньтой Түнтгэр хар өвгөн’ домог болно. Уг домогт санскрит хэлнээс гаралтай Лалар гэдэг ганц нүдтэй мангасын ганц нүдийг сохлон, агуйгаас хонины доор нуугдан гарч, амиа аварсан баатрын дүрээр илэрч байна (Цэрэнсодном, 1989: 141-142). Тус домгийн өөр нэгэн хувилбар болох *“Лал (Лалар)”* домогт өвгөний оронд хүүгийн дүрээр гарах нь бий. Уг домогт хүү Түнтгэр хар өвгөнтэй адилхан аргаар агуйгаас нь зугтаж *“Баруун газар очиж, ном сурч их эрдэмтэй сайн лам болсон...”* (тэнд, 142) гэдэг. Энэ бол өвгөний дүрийн өвөг дээдсийн онгод буюу бурхан гэсэн дүр заримдаа баатрын дүрээр хувирч илэрдгийн нэгэн жишээ юм.

2. Өвгөний дүрийн домог зүйн шилжилт ба хувирал

2.1. Хүү баатрын эцэг өвгөн

Долоон одны домгуудын *“Алтан гадас, долоон бурхан хоёр”*, *“Ам цагаан бяруу”*, Тувачуудын *“Долоон бурхан одны тухай домог”* гурван хувилбар болон *“Нар сар хоёр”* домогт өвгөн баатруудын эцгийн дүрээр гарчээ. Уг дөрвөн хувилбарт гардаг дүрүүдийн адил тал бол эцэг өвгөний хүү нь гол дүрээр гарч, баатрын үйл явдал өрнөдөг юм. Тухайлбал, *“Алтан гадас, долоон бурхан хоёр”* домогт өвгөний найман хүү нь өөрсдийнхөө эрдэм чадлыг нь ашиглаж Хангарди шувууны шүүрээд явчихсан гүнжийг олно. Өвгөнийг тэнгэр өөд харвасан алтан сумыг түрүүлж хүрсэн нь ав гэхэд отгон дүү нь алтан сумыг гүйцэж аваад алтан гадас од болсон ба хойноос нь явсан долоон ах нь долоон бурхан од болсон гэдэг. Хааны гүнжийг олж аварсан өгүүлэмжээс найман хүүгийн баатрын дүр, алтан гадас од болон долоон од болсон өгүүлэмжээс үлэмж биет баатрын дүр илэрч байна.

“Ам цагаан бяруу” домогт өвгөн эцэгтэй, үнээ эхтэй Ам цагаан бяруу нь цээжин бие нь хүн шиг болсон урт сүүлтэй үхэр шиг амьтны төрхөөр төрж хорлогч эмгэнийг дарж алсан чинь анд болсон Ой Дэлгэр, Модон Дэлгэр, Тэвшийн дэлгэр гэх гурван хуурамч баатруудад хууртаж гүн ангалын ёроолд ордог. Мөн Тэнгэрийн цагаан хааны өгсөн даалгаврыг хүлээн авч Шулмын хааныг алаад ордноос нь гарах гэтэл эмгэн төмөр эдрэнгээрээ цохисноор Ам цагаан бяруу долоон хэсэг болоход *“Тэнгэрийн цагаан хаан нэгийг нь ч газар унагаалгүй тэнгэрт авч гарч, огторгуйн долоон бурхан од болгосон”* (тэнд, 70) гэдэг. Уг домогт ч Ам цагаан бяруу гэдэг хүн-үхрийн заримдаг төрхтэй, өвгөн эцэгтэй хүү болж төрөөд хорлогчдыг дарсан баатрын дүр, долоон од болсон үлэмж биет баатрын дүр зэрэгцэн илэрч байна.

“Нар сар хоёр” домогт Хайрхан өвгөний цорын ганц хүү хамаг хүн амьтныг иддэг Хар мангасыг алж, харин Мангасын ээжийн хийсэн хортой ундааг ууж үхчихнэ. Үүнд, *“Хүүг үхэхэд хүн амьтан их тус ач болсон тул диваажинд*

төрүүлэх гэсэн чинь хүү дургүйцээж: Би диваажинд төрөхгүй ээ. Намайг мангастай ноцолдож байхад өнгөт гэрэлт өчүүхэн од тус болсон. Тийм болохоор хүн олонд тус ач болохын тулд од болж төрнө гээд тэнгэрт гарч сар болсон юм байна” (тэнд, х. 45) хэмээн Хар мангасыг дарж хүмүүсийг аварсан баатрын дүр, од болж төрнө гээд сар болсон үлэмж биет баатрын дүр зэрэгцэж илэрдгээр уг гурван домог дахь гарч буй хүү баатрын дүр ижилхэн байна.

Уг гурван домгийг авч үзэхэд өвгөн бол дандаа хүү баатрын эцгийн дүрээр гардаг. Энэхүү өвгөн хүү хоёрын дүр ихэнх шидэт ба баатарлаг үлгэрт адилхан гардаг. Д.Цэрэнсодномын Монгол ардын үлгэр номд нийтлэгдсэн 23 шидэт ба баатарлаг үлгэрүүдийн дунд 13 үлгэрт өвгөний дүр гардаг ба эдгээр үлгэрүүдийн дунд есөн үлгэрт баатар хүүгийн эцгийн дүрээр өвгөн гардаг. Тухайлбал, “Есгөлдэй өвгөн” үлгэрт Есгөлдэй өвгөний есөн хүү өөрсдийнхөө өөр өөр эрдэм увдисаар алга болсон хатныг олж хамгийн бага хүү нь хатнаа эхнэрээ болгож өвгөний алтан нум сумыг авна (Цэрэнсодном, 2015: 117-118). “Чихэн чинээ хүү” үлгэрт өвгөн эмгэн хоёрын хүү Чихэн чинээ хүү хааны зарлиг болгосон даалгаврыг гүйцэтгэж хааны ширээнд суух (тэнд, 131-133) ба “Ясан чавх, Чулуун чавх” үлгэрт бол Өвгөн эмгэн хоёроос төрсөн ихэр хүү эцгийг нь алсан Ясан чавх, Чулуун чавхнаас өшөөг авч эцгийнхээ ясыг нь цуглуулж ирнэ (тэнд, 148-151). “Хэвтээ хүүгийн үлгэр”-г мөн эмгэн өвгөн хоёроос төрсөн долоон настай хэвтээ хүү замдаа тааралдсан гурван хүний илбийн эд зүйлсийг авч өөрийг нь алах завдсан Боролдой хааныг хааны ширээнээс буулгаж өөрөө хаан суучихна (мөн тэнд, 156-159).

Энэхүү өвгөн эцэг-баатар хүү дүрүүдийн тогтолцооны учрыг эртний монголчуудын домог зүйн сэтгэлгээнээс олж болно. С.Дулам өвгөний дүрээр дүрслэгдсэн өвөг дээдсийн онгод буюу бутны эзэн болох бурхантай холбогдож үүссэн бутач гэдэг үгийн учрыг тайлбарлахдаа: *“Монголын түүхийн ном зохиолд тэмдэглэсэнээр гэрлэж төрлөөгүй зарц бүсгүйчүүдийн хүүхдийг овог удмыг самууруулна гэж үзээд бутны ёроолд хаядаг хатуу заншил эрт үед байсан бөгөөд түүний улмаас тийм бут бургасанд хаягдсан хүүхдийг “бутач” гэж нэрлэдэг болсон ажээ. Гэвч энэ нь тухайн үеийнхээ төсөөллөөр бол огт эзгүй хээр газар, гагцаар орхиж байгаа хэрэг бус, харин хүний өвөг дээдэс бутны эзэн болсон Бурха, Бурхандаа тушаан өгч байгаа хэрэг юм санжээ”* (1989: 54) хэмээн өгүүлжээ. Өнчин болсон хүү ер бусын хүч чадалтай, ид шидтэй, мэргэн цэцэн ухаантай байдаг нь бутны эзэн буюу бурхны сахиж өсгөсөн бутач хүүхэд аман зохиолд баатрын дүрээр илэрч, бутны эзэн буюу бурхныг өвөг дээдсийн онгод гэж үздэг нь аман зохиолд өвөг дээдсийн онгодыг өвгөний дүрээр дүрслэхэд хүргэсэн бололтой.

Энэхүү зан заншлаас гаралтай өгүүлэмжийг хадгалсан үлгэр бол “Гал улаан хаан” болно. Тухайлбал, жил бүр найман настай хүүхдээр далай тахидаг Гал улаан хаан далай тахисаар найман настай хүүхэд олдохоо байгаад түшмэдийн хүүгээр далай тахихаар болно. Түшмэдийн хүү зугтаж байгаад нэг их шуурга болж хийсээд хаягдсаныг нь хөх шартай өвгөн олж аваад хүүгээ болгоно (Цэрэнсодном, 2015: 118-119). Гал улаан хааны далайн тахилгын өргөл болохоос зугтаж байгаад өнчин болсон хүүг авч харийн орны баян хааны гүнжтэй гэрлүүлдэг эцэг өвгөний дүр илэрч байна.

Харин өвгөн бутны эзэн буюу бурхны шинжээ их алдсан байдалтай хүү баатрын эцгийн дүрээр гарч онцгой үйл явдлыг өрнүүлдэггүй, эргэн тойрны дүрээр хоцордог учрыг тайлбарлана гэвэл, хүн төвт үзэл үүсэж бурхдын үйл

явдлаас илүү хүний төрхт баатруудын үйл явдал нь давамгайлдаг болсон ба бурхдын дүрүүдийг хүншүүлж дүрсэлдэг болсонтой холбоотой. Бурхдын шийдвэр бүхий өгүүлэмжээс хүмүүн баатруудын үйл явдалт өгүүлэмж рүү шилжихэд бутны эзэн буюу өвгөн бурхны сахисан бутач хүүхэд нь аман зохиолын баатарлаг туульсын төрөл дээр өвгөн эцгийн цорын ганц хүү баатрын дүрээр илэрсэн бол ардын үлгэрт өнчин хүүгийн дүрээр илэрч, гол баатрын байр сууринд ирсэн байна. Харин бутны эзэн буюу өвгөний дүр нь баатарлаг явдалт өгүүлэмж дээр бурхны шинж нь буурч, хүү баатрын эцгийн дүрээр үлджээ. Өөрөөр хэлбэл, домог зүйн дүрийн тогтолцоонд бурхны дүрийг төлөөлж байсан өвгөний дүр нь үлгэр туульсын гол дүрийн суудлыг эзлэх өрсөлдөөнд эр зоригтой, нас бага цус шингэн хүү баатрын дүрд ялагдсанаар баатрын эцэг юм уу туслах адуучны дүрээр үлджээ тогтсон гэж үзэж болно.

Энэхүү үүднээс үзвэл эртний одон эрхсийн домогт долоон өвгөн буюу долоон бурхан одыг хүү баатруудын дүрээр дүрсэлдэг нь ойлгомжтой болно. Тодруулбал, долоон одны үүслийг тайлбарласан эртний домогт туульсын хүн төвт үзэл нөлөөлж, хүү баатруудын баатарлаг үйл явдалт өгүүлэмж болон хувирч ам дамжин өвлөгдөж ирсэн байж болно. Өөрөөр хэлбэл, долоон од буюу долоон бурхан болох өвгөний дүрийг хожим хүү баатрууд оролдог болсон ба долоон одны шүтлэг, зан үйл, монголчуудын домог зүйн сэтгэлгээнд харин долоон өвгөний дүр хэвээр үлдсэн юм.

2.2. Тэнгэр эцэг ба өвгөн

Домог зүйгээс баатарлаг туульс руу шилжиж үед тэнгэрийн хүү баатрын дүр илэрч эхэлдэг. Монголчуудад тэнгэрийн үзэл, бөөгийн шашин давамгайлж дэлхийн эзэн газар эх Этүгэн, бутны эзэн бурхнаас илүү Хөх мөнх тэнгэр, Хурмаст тэнгэрийг оруулаад баруун зүгийн 55 тэнгэр, зүүн зүгийн 44 тэнгэр гэх мэт тэнгэр нарыг, ялангуяа феодалын нийгэм болон улс төрийн хүрээнд их хүндэлж шүтдэг болжээ. Үүнд өвгөний дүр хүртэл улам цаашилж одон эрхсийн шүтлэгтэй холбогдож долоон өвгөний шүтлэг үүсэж долоон одны маань болон одон эрхсийн үүслийн тухай домогт ул мөр нь үлдсэн ба өвгөнийг бөөтэй адилтгадаг зан үйл, аман зохиолын жишээнүүдийг үзэхэд өвгөн бурхан гэсэн үзэл ойлголт давхар нотлогдсон байна. Тэнгэрийн үзэл давамгайлснаар өвгөн тэнгэр хоёрыг хүртэл адилтгасан жишээ нь аман зохиолд мөн байна. Тухайлбал, “Гэсэр” туулийн олон хувилбарт Гэсэр баатрын дээд тив буюу тэнгэр дахь эцгийн дүрээр Хурмаст тэнгэр, харин дунд тив буюу газар дэлхий дахь эцгийн дүрээр өвгөн эмгэн хоёр гардаг. Чухам ихэнх баатарлаг туульд хүү баатрын эцгийн дүрээр өвгөн гардаг нь түгээмэл ба Гэсэр туульд дээд тив буюу тэнгэрийн оронд оршдог 99 тэнгэр нэрийн пантеон болон түүхийг дэлгэрэнгүй дүрсэлдэг нь монголчуудын дунд тэнгэрийн үзэл давамгайлж аман зохиолд мөн адил нөлөөлснийг харуулж буй хэрэг мөн.

Урианхайн нэрт туульч Хоо Живэртийн Мэнгитийн ач хүү Э.Баатаржавын хайлсан “Баян цагаан өвгөн” туульд *“Баян цагаан өвгөн Арван цагаан уулсын авралт эзэн болон төржээ. Эмгэн өвгөн хоёрын өхийх нуруу өвгөрөх нас ойртоод ирэх үед дээд Хан хурмастын таван хаан хурмаст дунд замба тивд орж ирээд арван цагаан уулсын орой дээр алтан толгойтой таван хунд хувилж орж ирээд дунд замба тивийн олон зүйлийн амьтныг амгалан тайван суулгахын төлөө... хорон шүү ихдэж хортон дайсан олироод ирэх үед... Баян цагаан өвгөн Буйман улаан хатан хоёрт отгон хурмастыг үр бол гээд далай цагаан өргөөний*

нь баруун цамхраагаар (тооны нүх) таван өнгийн солонго татуулаад тэнгэрийн ариун тохиолгоонт үр сад заяалгаж өгөөд алтан толгойтой таван хун дээд хаан хурмаст нутгаа зорив. Баян цагаан өвгөний Буйман улаан хатнаас нэг настай нялх үстэй баатар бал улаан хүү мэндэлжээ” (Катуу, 2015: 43-44). хэмээн баатар баал улаан хүүгийн дунд тив дэх эцгийн дүрээр Баян цагаан өвгөн, харин дээд тив дэх эцгийн дүрээр Хурмаст тэнгэр илэрч байна. “Гэсэр”, “Баян цагаан өвгөн” зэрэг туульд хүү баатрын эцгийн дүрээр тэнгэр, өвгөн хоёр зэрэгцэн илэрдэг нь эртний домгийн сэтгэлгээнд өвгөнийг бутны эзэн буюу өвөг дээдсийн онгодын дүрээр дүрсэлж бурхан гэж үздэг байсан бол феодалын нийгмийн үед улс төр байгуулж, олон угсаатныг нэгтгэхэд тэнгэр шүтлэг нөлөөлсөнтэй холбоотойгоор эцэг тэнгэрийн дүр нэмэгдэж илэрсэн гэж ойлгож болно. Чухамдаа тэнгэрээс бууж ирээд гэрийн тооны нүхээр үр сад заяагдаж жирэмсэн болох өгүүлэмж “Монголын нууц товчоо”-нд шар хүн гэрийн өрх, тотгоны зайгаар орж ирээд Алангуа эхийн хэвлийг илж гэгээ гэрэл нь хэвлийд шингэж Чингис хааны Боржгин овгийн өвөг дээдэс болсон Бодончар хүү төрсөн гэдэг домогт мөн адил гарч байна. Монголын эзэнт гүрний түүхэн сурвалжуудад ч Чингис хааны өвөг дээдэс нь тэнгэрийн удамтай гэдгийг онцолж дурдсан (Сүхбаатар, 1992: 136-138) нь дундад зууны үед аль хэдийн тэнгэрийн үзэл давамгайлж ардын шүтлэг, бөөгийн шашин, аман зохиол болон зан үйлд давамгайлж нөлөөлдөг байсныг нотолж байна. Мөн аман зохиолд хүү баатар, тэнгэр нарын дүрүүд зонхилох болсон нь өвгөний дүрийн бурхны шинжийг бууруулж, гол дүрээс туслах дүр рүү шилжихэд давхар нөлөөлсөн байна.

2.3. Аг сахал буюу адуучин өвгөн

Монгол баатарлаг туульд хамгийн түгээмэл гардаг өвгөн бол адуучин Аг сахал өвгөн юм. ‘Аг сахал’ гэдэг үгийг шинжлэн задалбал аг гэдэг нь түрэг хэлний ‘ак’ буюу цагаан гэсэн утгатай, сахал гэдэг нь түрэг хэлний ‘сакал’ буюу мөн адил сахал гэсэн утгатай. Түрэг хэлт үндэстнүүдийн аман зохиолд Ак сакал өвгөн их гардгийг ажиглахад түрэг хэлт үндэстнүүдийн аман зохиолд гардаг Ак сакал өвгөний дүр монгол ардын туульд гардаг Аг сахал өвгөний дүрд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэх нь зүйтэй.

Өвгөний цагаан сахал бол мөнх шинжийг бас хамаарах болно. Үргэлж хөх өнгөтэй байдаг “Хөх мөнх тэнгэр”-ийг монголчууд эртнээс шүтэж ирсэн (Дулам, 2020: 27-28) ба мөнх ногоон модны домгуудад шилмүүст моддын дээр мөнхийн рашаан ус асгарч мөнх шинжийг олж мөнх ногоон өнгөтэй болдог (Цэрэнсодном, 1989: 80-83). Уулын шүтлэг болон магтаалд мөнх цагаан уулыг дээд буюу толгойн хэсэг нь цагаан байдгийг уулын эзэн буюу савдаг өвгөний цагаан үстэй толгойтой зүйрлэсэн илэрхийлэл юм. Өвгөний сахал бол хүний үсний фетишизм дээр цагаан өнгөний бэлгэдэл нэмэгдсэн нь монголчуудын соёл сэтгэлгээнд амь бөхтэй дурсагдаж байгаа билээ. “Халх ардын тууль” номд нийтлэгдсэн “Агийн улаан хаан” туульд,

“Адууч өвгөнөө дуудав гэнэ

Агт уруугаа давхиулав гэнэ

Агтын дээд

Хурдан хонгор морио

Авчир гэж тушаав гэнэ” (Нарантуяа, 1991: 26)

гэж Агийн улаан хаан баатар адуучин өвгөнд хүлэг морио бэлтгэхийг тушаал болгоно.

“Нэгэн зуун тавин таван насыг насалсан хөгшин луу мэргэн хаан” туульд олон тооны өвгөний дүр гардаг. Хөгшин луу мэргэн хаан өөрөө зуун тавин таван настай өвгөний дүрээр гарч байгаа бөгөөд түүний тэмээчин шар өвгөн, адуучин Агсахал сайн өвгөн хоёр гардаг. Хөгшин луу мэргэн хаан,

“Хаан хүн байтлаа
Харц нүд булаах хүүгүй
Яахав гэж гунигланхан суужээ” (тэнд, х. 78)

гэж байтал Аг сахал адуучин өвгөн,

“Тэнгэр өөд гарч
Тэнгэрийн ламаас
Хөгшин хааныхаа зовлонг асууж
Айлдахаар явав гэнэ” (тэнд, х. 78)

гэж нисдэг морио унаж, тэнгэр өөд гардаг нь “Болдоггүй Борлозой өвгөн” үлгэрт гардаг бор өвгөнийг санагдуулж байна. Тэнгэрийн лам “*тэнгэрийн жигүүртэн бор морийг барьж сэтэрлэвэл*” (тэнд, 78) нэг хүү төрнө гэхэд Хөгшин хаан тэр ёсоор гүйцэтгэж жигүүртэн бор морио сэтэрлэж, гурван бор морь “*Тэнгэрийн гахай хар бодонг сэтэрлэвэл улам сайн хүү гарна*” (тэнд, 79) гэхэд тэр ёсоор гүйцэтгэж ‘Хөх торгон дээлтэй Том хар хүү’-гэй болно. Харин Хөгшин хаан хорин таван толгойтой хотгор хар мангаст залгиулж үхэхэд хүү баатар нь Агсахал өвгөний тусламжтайгаар замд гаран, мангасыг дарж, эцгийнхээ сүй тавьсан Догшин Жангарай хааны охин Усан Дэмбий дагиныг Тэнгэрийн тайжтай эрийн гурван наадам хийж дийлээд эхнэр болгон авна. Энд Хөгшин мэргэн луу хаан бол баатрын эцэг хааны дүрээр, Агсахал өвгөн бол баатрын туслагч дүрээр зэрэгцэн гарч байгаа юм. Дээр өгүүлсэнчлэн өвгөн бурхны дүр, хүү баатрын дүртэй өрсөлдөж ялагдсанаар бутны эзэн өвгөн бутач хүүхдийг сахиж өсгөдөг домог зүйн сэтгэлгээний нөлөөнд хүү баатрын эцэг дүрээр шилжиж хувирсан бол улам өөрчилж хүү баатрын туслагч дүрээр гардаг болсон байна. “Нэгэн зуун тавин таван насыг насалсан хөгшин луу мэргэн хаан” тууль бол эцэг хаан өвгөний дүр Аг сахал гэгч баатрын туслагч дүр лүү шилжих явцад уг хоёр дүр зэрэгцэн илэрсэн чухал жишээ болж байна

Ийнхүү өвгөний дүр нь домог зүйн шатанд “бурхан” буюу өвөг дээдсийн онгод, уулын эзэн, үлэмж биет баатар гэхчлэн гол дүрийн үүрэгтэй байсан бол баатарлаг туульсын үе болоход гол баатрын эцэг, адуучин гэх мэт туслах дүрээр илэрч байгааг жишээгээр харууллаа. Цаашид домог зүйн өвгөний дүр буюу бурхан-өвөг дээдсийн онгон дүр нь чухам ямар шалтгааны улмаас хэрхэн уулын эзэн савдаг буюу байгалийн эзэн болж хувирсан хийгээд аман зохиолоор уламжилсан олон зүйл өвгөний дүрийг бид дараагийн өгүүлэлдээ нарийвчлан судлах болно.

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгааны гол хэлэлцүүлэг нь монгол домог зүйн өвгөн (бурхан)-ий дүрээс хэрхэн уулын эзний дүрд шилжсэн шилжилт хийгээд монгол үлгэр туульс дахь өвгөний дүрийн домог зүйн үндсийг тодруулсан тайлбар судалгаанд төвлөрч байна.

Монголын эртний домог, баатарлаг тууль, түүх домог, үлгэр гэх мэт аман зохиолууд, бөө мөргөлийн болон буддын шашны ёсонд олон янзын өвгөний дүр

гардаг боловч өвгөний дүрийг гол сэдэв болгон судалсан судалгаа тун ховор байна. Тиймээс энэхүү өгүүлэлдээ монгол аман зохиол дахь өвгөний дүрийг домог зүй, зан үйлийн онолын үүднээс судлахыг зорьж, Ж.Фрэзер, С.Дулам нарын домог зүйн судалгааны онолын үзэл баримтлал, арга зүй хийгээд В.Хайссиг, Ли Анна нарын шашин шүтлэгийн судалгааны үр дүнд тулгуурлан монгол аман зохиол дахь өвгөний дүрийн домог зүйн үүтгэл хийгээд шилжилтийг тодруулсан болно.

Дүгнэлт

1. Эртний домог (myth), түүх домог (legend)-ийн жишээнээс өвгөний дүрийг бүртгэж үзвэл, эртний домог дахь өвгөний дүр нь бурхан өвгөн хоёрыг адилтгадаг үзэл төсөөлөл хийгээд долоон өвгөн одны шүтлэгийн нөлөөнд үүссэн байна.
2. Баатарлаг туульс болон хүүрнэн өгүүлэх аман зохиолд гардаг өвгөний дүрийн эх үүтгэл хэлбэр нь эртний домогт бутны эзэн- бурхан, тэнгэрт дэвшсэн өвөг дээдэс, уулын эзэн, үлэмж биет баатар, мэргэн төлөгчийн дүрээр илрэн гарч байна.
3. Домог зүйн өвгөний дүр нь эхэндээ бут бургасны эзэн-өвөг дээдсийн онгод гэсэн эртний шүтлэгийн хүрээнд үүссэн боловч дараа нь тэнгэр шүтлэгт, улмаар бөөгийн шашны үзэл нөлөөгөөр өндөрлөг газар буюу уулын эзний шүтлэг болон хөгжиж, өвгөний дүр нь бурхан-хүмүүний заримдаг шинжтэй, тэнгэр-хүмүүн хоорондын гүүр холбогчийн үүрэгтэй болж ижилсэж буй нь ажиглагдаж байна.
4. Мөн өвгөний дүрээс уулын эзэн болон угсаатны овгийн өвөг дээдсийн дүрийн үүтгэлийг ажиглахад домог зүйн өвгөний дүр нь бурхны шинжээ алдаж, үлгэр туульсын үе болоход чиг үүргийн хувьд гол дүрийн эцэг юм уу туслагч адуучны дүрээр гарах болсон байна
5. Өвгөний дүр нь ямар шалтгаанаар гол баатрын туслагч юм уу эцгийн дүрээр зонхилж илрэх болсон тухайд авч үзвэл эртний домгоос баатарлаг туульст шилжих үед хүү баатрын эцгийн дүрээр өвгөний оронд тэнгэр зонхилж гарч эхэлсэн нь тэнгэрийн шүтлэг давамгайлсантай холбоотой бөгөөд энэ нь эртний домог руу урвуу нөлөөлж, өвгөн бурхны дүрийг хүү баатрууд нь орлох болсноор өвгөн бол хүү баатруудын эцэг юм уу туслах дүрээр үлдэж хоцорсон байна.

Ном зүй

а). Монгол хэлээр

- Дулам, С. (1989). *Монгол домог зүй*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Dulam, C. Mongol domog züi [Mongolian mythology]. Ulaanbaatar: National Publishing House. 1989.]
- Дулам, С. (2020). *Монгол бэлгэдэл зүй I*. Улаанбаатар: Битпресс ХХК, [Dulam, C. Mongol belgedel züi- I [Mongolian symbology- I]. Ulaanbaatar: Bitpress LLC.

- 2020.]
- Дулам, С.** (2020). *Монгол бэлгэдэл зүй II*. Улаанбаатар: Битпресс ХХК. [Dulam, S. Mongol belgedel züi- I [Mongolian symbology- II]. Ulaanbaatar: Bitpress LLC. 2020.]
- Катуу, Б.** (2015). *Баян-Алтайн гуч Э.Баатаржавын хайлсан туульс*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Katu, B. Bayan-Altain guch E.Baatarjavyn khailsan tuulis [Epic Recited by E. Baatarjav, a Bard (Tuulchi) of the Bayan-Altai]. Ulaanbaatar: Soyombo printing. 2015.]
- Нандинбилиг, Г., Дулам, С.** (2020). *Монгол аман зохиолын онол II*. Улаанбаатар: МУИС пресс хэвлэлийн газар. [Nandinbilig, G., Dulam, S. Mongol aман zokhiolyn onol-II [The Theory of Mongolian Folklore-II]. Ulaanbaatar: MUIS press printing. 2020.]
- Нарантуяа, Р.** (1991). *Халх ардын тууль*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Narantuya, R. Khalkh ardyn tuuli. [Epic of the Khalkha People]. Ulaanbaatar: National Publishing House. 1991.]
- Өрнөхдэлгэр, Д., Нямдаваа, Г.** (2022). *Монгол Улс дахь Түрэг угсаатны аман билгийн товчоон*. Улаанбаатар: МУИС пресс хэвлэлийн газар. [Urnudelger, D., Nyamdavaa, G. Mongol Uls dahi Tureg ugsaatny аман bilgiiн товchoon. [An Anthology of Turkic Oral Traditions in Mongolia]. Ulaanbaatar: MUIS press printing. 2022.]
- Сампилдэндэв, Х.** (1984). *Монгол домог*, Улаанбаатар: Улсын Хэвлэлийн газар. [Sampildendev, Kh. Mongol domog. [Mongolian Legends]. Ulaanbaatar: National Publishing House. 1984.]
- Сампилдэндэв, Х.** (1999). *Монгол домгийн чуулган*, Улаанбаатар: Интерпресс. [Sampildendev, Kh. Mongol domgiin chuulgan. [Anthology of Mongolian Legends]. Ulaanbaatar: Interpress printing. 1999.]
- Цэрэнсодном, Д.** (1989). *Монгол ардын домог үлгэр*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Tserensodnom, D. Mongol ardyn domog ulger. [Myths of The Mongolian people]. Ulaanbaatar: National Publishing House. 1989.]
- Цэрэнсодном, Д.** (2015). *Монгол ардын үлгэр*. Улаанбаатар: Тод бичиг ХХК. [Tserensodnom, D. Mongol ardiin ulger. [Myths and Folktales of The Mongolian People]. Ulaanbaatar: Tod bichig LLC.]
- Сүхбаатар, Г.** (1992). *Монгол Нирун Улс*. Улаанбаатар: Эрдэм. [Sukhbaatar, G. Mongol Nirun Uls. [The Mongol Nirun State]. Ulaanbaatar: Erdem printing. 1992.]

б). Гадаад хэлээр

- Жирмунский, В. М.** (1962). *Огузский героический эпос-Моего деда Кorkута*. Ленинград: Издательство академии наук СССР. [Jirmunskii, W.M. Oguzskii geroicheskii epos-Моего deда Korkuta. [The Book of My Grandfather Korkut – Oguz Heroic Epic]. Leningrad: Publishing House of the Academy of Sciences of the USSR. 1962.]
- 안나, 이. *몽골 민간신앙 연구*. 서울: 한국문화사. [Anna, Lee. Mongol mingansinang youngu. [A Study of Mongolian Folk Beliefs]. Seoul: Hanguk Munhwasa printing. 2010.]
- 인섭, 정. *한국의 설화*. 용인: 단국대학교출판부. [In-seop, Jeoung. Hanguk-ui Seolhwa. [Folk tales from Korea]. Yong-in: Dankook University printing. 2007.]

- 재훈, 정. *돌궐유목제국사*. 서울: 사계절. [Jae-hun, Jeoung. Dolgoel Yumoek Jeguksa. [The History of the Turkic Nomadic Empire]. Seoul: Sagejul printing. 2005.]
- 진태, 손. *조선설화집*. 서울: 민속원. [Jin-tae, Son. Joseon Seolhwa-jib. [Anthology of Joseon Folktales]. Seoul: Minsokwon printing. 2009.]
- 하이시히, 발터. зохиолч. 평래, 이. Орчуулагч. (2003). *몽골의 종교*(*Монголын шашин суртахуун*). 서울: 소나무. [Heissig, W. Die Religionen der Mongolei[Mongol-ui Jonggyo]. Translated by Pyung-rae, Lee. Seoul: Sonamu printing. 2003. [Original work published in 1970].



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See:

<http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>